

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 41

1.	<i>“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30- ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	9 – 25
2.	<i>Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт</i>	25 – 38
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/</i>	38 - 41

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 21-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 03 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, С.Лүндэг, М.Мандхай, Ц.Мөнхбат, А.Ундраа;
Чөлөөтэй: Т.Аубакир, Г.Ганбаатар, С.Ганбаатар, З.Мэндсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бейсен, Л.Мөнхбаясгалан.*

***Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын
хороонд хүргүүлнэ./***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн З.Райынбек, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөц, бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Эрдэнэцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Д.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 3.6.5 дахь заалт нэмэх:

“3.6.5.Цөлжилттэй тэмцэх, гангийн үр нөлөөг бууруулах, бэлчээрийн газрын тогтвортой менежментийг сайжруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Бат-Эрдэнэ: Төслийн 1 дүгээр хавсралтын 3.6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 3.6.5 дахь заалт нэмэх:

“3.6.5.Цөлжилттэй тэмцэх, гангийн үр нөлөөг бууруулах, бэлчээрийн газрын тогтвортой менежментийг сайжруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 7

Бүгд: 13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.10 дахь заалт нэмэх:

“3.4.10.“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд газар тариалан, өмнөх түвшиндээ хүрч чадахгүй байгаа баруун бүс нутгийн гурилын үйлдвэрийг сэргээн хөгжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлж, үйлдвэрлэл, хангалтыг нэмэгдүүлэх суурийг тавих.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.11 дэх заалт нэмэх:

“3.4.11.Газар тариалангийн салбарт үрийн үйлдвэрлэл, чанарт тавих стандартыг онцгой анхаарч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон өндөр ургац өгдөг, чанартай, баталгаат үрээр хангах үрийн аж ахуйнуудыг бэхжүүлэх дэмжлэг урамшууллын тогтолцоо нэвтрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.12 дахь заалт нэмэх:

“3.4.12.Хүн амын хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүн хүнсний түүхий эд улаан буудайн стратегийн нөөцийг бүрэн бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.2.5 дахь заалт нэмэх:

“1.2.5.“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг эрчимжүүлж, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулж, бүсийн онцлогт тохирсон газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлд “Шинэ хоршоо 2.0” арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.14 дэх заалт нэмэх:

“2.1.14.”Малчин залуу-манлайлагч” арга хэмжээг үргэлжүүлж, малчид хоршоологчдод мал аж ахуйн гаралтай түүхий эд, бэлтгэлийн үйл ажиллагаанд бүс нутаг, олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмших, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах ур чадварыг гадаад улсад олгоход чиглэгдсэн төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.10 дахь заалт нэмэх:

“3.4.10.Малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн үе шат бүрт стандарт нэвтрүүлж, мал аж ахуйн салбарын кластерийн тогтолцоог бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Д.Баярсайхан, Хүнсний үйлдвэрлэлийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч Б.Амарзаяа, Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж, үйлдвэрлэл технологийн парк хариуцсан ахлагч шинжээч Ч.Ариунтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, М.Ганхүлэг, П.Батчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Д.Баярсайхан, Хүнсний үйлдвэрлэлийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч Б.Амарзаяа, Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж, үйлдвэрлэл технологийн парк хариуцсан ахлагч шинжээч Ч.Ариунтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг үг хэлэв.

Б.Бат-Эрдэнэ: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 18 минут үргэлжилж, 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 03 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм Улсын Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж 54.2 хувийн ирцтэй болсон учраас 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдөр 2025 оны 05 сарын 21-ний өдрийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд 2 дугаар тойрог Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн, 5 дугаар тойрог Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн, 4 дүгээр тойрог Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, жагсаалтаар орсон Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн, жагсаалтаар орсон Сонгобайн Замира гишүүн ирсэн, 6 дугаар тойрог Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн, жагсаалтаар орсон Бадрахын Найдалаа гишүүн ирсэн, 7 дугаар тойрог Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн, 6 дугаар тойрог Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн, 7 дугаар тойрог Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн, жагсаалтын Болдын Уянга гишүүн ирсэн, 8 дугаар тойрог Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн.

Ингээд нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн учраас өнөөдрийн хуралдаан маань албан ёсоор эхэлсэн гэдгийг дахин мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх холбоотой асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээр асуудал. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг сонсох.

Гуравдугаар асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл. “Засгийн газраас чиглэл өгөх тухай” Байнгын хорооны төсөл гэсэн ийм гурван асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Баталъя. Хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүн байхгүй учраас шууд асуудал руугаа хэдүүлээ ороод явъя.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,

хоёр дахь хэлэлцүүлэг,

Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Нэгдүгээр асуудал. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг урьж байна. Ажлын хэсгийг та бүхэндээ танилцуулъя.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Жадамбын Энхбаяр гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яам Идэшийн Батхүү Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвээндоржийн Эрдэнэбат ирсэн байна. Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лхагвабаярын Энх-Амгалан орж ирж байгаа юм байна. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Доржготовын Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лхагвасүрэнгийн Балчинлуvsан, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батчулууны Мөнгөсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга Очиржанцаны Мөнхтөр, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Зияханы Райынбек, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Галиндэвийн Отгонцэцэг.

Сангийн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал нар ирсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэцэгмаагийн Уртнасан, Байгалийн нөөц, бодлогын хэрэгжилтийн газрын дарга Цэрэндоржийн Уранчимэг, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Сугарын Эрдэнэцэцэг.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Дангаасүрэнгийн Баярсайхан нар өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн байна.

2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан шууд асуулт хариулт руугаа орчихно. Тийм ээ. Асуулт саналтай байгаа гишүүн байвал нэрсээ өгье.

Ж.Батжаргал гишүүн, Н.Наранбаатар гишүүн, Жадамбын Энхбаяр сайдаар тасаллаа.

Жигжидийн Батжаргал гишүүнийг микрофонд урьж байна. Н.Наранбаатар гишүүн. Ирцээрээ юм байна. Н.Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар гишүүнийг урьж байна.

Н.Наранбаатар: Ажлын хэсэгт энэ өдрийн мэнд хүргэе. Хөдөө аж ахуйн яамнаас тодруулъя.

Энэ жилийн ноолуур бэлтгэлийн ажил ер нь ямар шатандаа явж байна вэ? Мэдээлэл өгөөч ээ. Ялангуяа говийн бүс, баруун бүсийн ноолуур бэлтгэлийн ажил ямар хэмжээнд явж байна. Үнэ ханш ямар байна гэдэг дээрээ мэдээлэл өгөөдхөөч ээ. Тэгээд дараа нь асууя.

Ирэх жил ер нь хэдий хэмжээний ноолуур бэлтгэл явах юм? Бас ямар зохион байгуулалтаар энэ ажлаа хийх юм бэ? Яаж төлөвлөж байгаа вэ гэсэн. Тэгээд дараа нь тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Нанзадын Наранбаатар гишүүний асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр хариулна.

Ж.Энхбаяр: Гишүүний асуултад хариулъя.

Жилийн эцсээр тоологдсон ямааны тоог тооцоолоод гарахад 8300 тонн нийт бохир ноолуур гарахаар байна. Үүнийгээ самнаад боловсруулалт хийхэд 4150 тонн самнасан ноолуур болно. Үүнийхээ 2500 тонныг нь экспортод гаргахаар үндсэндээ гэрээ хэлцлүүд нь хийгдсэн. Үлдсэн 1500-гаар нь дотоодын үйлдвэрлэлүүд эцсийн бүтээгдэхүүн хийх гэсэн ийм зорилготой ажиллаж байгаа.

Үндсэндээ ноолуур маань байгаль цаг уур, малын үржил селект, өвөлжилт гээд олон хүчин зүйлээс хамаараад үнэ янз янз тогтож байгаа. Жишээлбэл, зүүн аймгийн ноолуурууд 155-аас 168 мянган төгрөгөөр арилжаалагдаад дууссан. Төвийн бүс 130-аас 140 мянга дээр дууссан. Одоо хангайн бүс, хойд бүс дээр ноолуур идэвхтэй явагдаж байна.

Хамгийн үнэ бага байгаа нь манай говийн бүсийн ноолуур. Ширхгийн хувьд янз янзын тал байна. Дээрээс нь нэлээн байгалийн бохирдол нэлээн өндөр буюу ноолуурын гарц бага байгаа. Гэхдээ үнэ бол 100 мянгаас доош буухааргүй ингэж авагдаж байна.

Өнөөдрийн байдлаар нийт ноолуурын 60 хувь үндэсний үйлдвэрүүд авсан байна. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд гаргасан эх үүсвэр бүрэн ашиглагдсан. Монголбанктай сая ярьж байгаад бид арилжааны банкууд, ноолуурын холбоо, үйлдвэрүүдтэйгээ хамтраад өрийн бичиг гарах асуудал шийдэгдсэн. Одоо гэрээн дээрээ орж байна.

Ямар ч байсан энэ жил ноолуурыг дотоодын үйлдвэрүүд авахад санхүүгийн ямар нэгэн эх үүсвэрийн дутагдалгүй байх ийм зохион байгуулалттай арга хэмжээг аваад дуусаж байна.

Одоо 05 сар гараад ирэхээр баруун 5 аймгийн гол ноолуур идэвхжиж самналт явагдаж байна. Тэнд авч байгаа үнэ бол өдөр болгон үнэ гарч нийгмийн сошиал орчинд мэдээлж байгаа. Хамгийн доод талдаа буюу говийн бүсэд 100 мянга. Тэгээд л дээшээ 100 мянгаас 140 мянгын хооронд ширхгийн ялгаатай байдлаас ноолуурын худалдан авалт одоо явагдаж байна.

Монголбанкны энэ асуудал маань одоо эцэслээд үндсэндээ гэрээндээ орж байна. Нийтдээ 500 тэрбум төгрөгийн вексель, өрийн бичиг гаргаж байгаа. Энэ бол энэ жилийн ноолуурыг бүрэн худалдан авахад хангалттай.

Нөгөө талаас бас урд хөршийн аж ахуйн нэгжүүд нэлээн хүлээж харж байгаад бидний шийдвэр хэрэгжээд ирсний үр дүнд бас урд хөршөөс нэлээн хэмжээний бэлэн мөнгө орж ноолуур худалдан авалт бас давхар идэвхжиж байгаа.

Тэгэхээр ноолуурын энэ жилийн бэлтгэл ингээд амжилттай, үндэсний үйлдвэрүүд сүүлийн 30 жил анх удаа ноолуураа дотоодоосоо бүрэн хангаад экспортлох чадавхыг бүрдүүлээд үйлдвэрлэлээ өргөтгөөд.../минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: Нэмж хариулах уу. Та. Ж.Энхбаяр сайдын микрофоныг нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Ноолуур дээр өмнө угаагаад түүхий ноолуур гаргадаг байсан бол одоо самнадаг болсон. Шинэ шатанд гарсан. Үүний үр дүнд Монгол Улсын ноолуурын үнэ цэн нэмэгдэнэ. Ноолуураас дотооддоо үлдэх ашиг 500-аас 700 тэрбум төгрөгийн зөрүү өртөг Монгол Улсад цалин хөлс, татвар болж үлдэж байгаа.

Яг одоо урд хөршид нэг кило цагаан ноолуур 128 мянган төгрөгийн үнэтэй байгаа боловч идэвхжилт туйлын сул байна. Яагаад гэвэл Хятад, Америкийн худалдааны тарифын зөрчил шийдэгдээгүй байна. Үүнтэй холбоотойгоор харин бид энэ хугацаанд үйлдвэрээ өргөтгөөд, самнах хүчин чадлаа хийж чадсан тул манай үндэсний үйлдвэрүүд идэвхтэй ажиллаад ноолуураа дотоод зах зээлээсээ бүрэн бэлдээд ноолуурынхаа ард гарах ийм төлөвтэй байна.

Б.Бат-Эрдэнэ: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Ирэх жил хэдий хэмжээний ноолуур бэлтгэх юм? Эх үүсвэр яаж төлөвлөж байгаа юм? Ямар ямар эх үүсвэрээс хичнээн хэмжээний төсөв хөрөнгө ирэх жилийнх дээр тавьж байгаа. Энэ жил бол бас малчид маань нэлээн л, ялангуяа говийн, баруун бүсийн малчид маань нэлээн л зүдрэх шиг боллоо.

Хоршооны зээл ав гэж байгаад ноднин авахуулчихсан. Энэ жил ноолуур нь үнэ ханшгүй болсон. Авч байгаа газар байхгүй. Хүнд л байх шиг байна малчид маань.

Тийм учраас бид эртнээс бас үүнийгээ сайн төлөвлөж зохион байгуулах ёстой гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр хариулт авъя.

Б.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд. Ж.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Ноднин төсөв дээр дотооддоо ноолуураа 100 хувь үйлдвэрүүд авах ийм санхүүг оруулж ирсэн боловч төсвөөр хасагдсан.

Тэгэхээр энэ жил тэрийг бас дахин оруулж ирсэн. Бас хассан байгаа. Энэ дээр мэргэжлийн Байнгын хороо анхаарч үндэсний үйлдвэрүүд ноолуур худалдан авахад зориулсан эх үүсвэрийг төсөвт суулгах шаардлагатай.

Бид сая хоёр дахь хувилбар буюу Монголбанктай ярьж өрийн бичиг гаргаад, вексель хэлбэрээр, өрийн бичгээр ноолуур худалдан авах ажиллагааг анх удаа зохион байгуулах гэж байна. Энэ бол бас хоёр дахь хувилбар байгаа юм.

Тэгэхээр энд үндсэн үйл ажиллагаа, нөгөө бид өргөн барьсан төслөөс ялангуяа ноолуурын чиглэлийн ажлууд нэлээн хасагдсан байгаа гэдэг дээр анхаараад санал хураагаад нэг шийдвэл их сайн байна.

Б.Бат-Эрдэнэ: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний хөдөө аж ахуй, байгаль орчинтой холбоотой дэвшигдэж байгаа зорилт, арга хэмжээнүүдийн талаар бид тодорхой мэдээлэл авах шаардлагатай байна.

Тэгэхээр эдийн засгаа төрөлжүүлэе, эдийн засгийнхаа өсөлтийг нэмэгдүүлэе, хүнсний хангамжаа, аюулгүй байдлаа сайжруулъя гээд олон зорилтот хөтөлбөр, аян, хөдөлгөөнүүдийг өрнүүлээд ажиллаж байгаа. Хооронд нь уялдааг нь хангаж ажиллаж байгаа.

Тийм учраас 2026 он бол бас энэ том бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангахад онцгой жил нь байгаа.

Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт өмнөх он жилүүдэд хэрэгжүүлж эхэлсэн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгийн дэмжлэг, урамшуулал, чөлөөлөлтийн асуудлууд 2026 онд ер нь яаж хэрэгжихээр төлөвлөгдөж энэ төлөвлөгөөнд тодорхой суув гэдэг асуудал байгаад байна.

Хоёр дахь зүйл. Монгол Улс өөрөө нэлээн өргөн уудам нутаг дэвсгэртэй, эдийн засгийн чадамж нь бүсүүдтэй харилцан адилгүй байгаад байгаа. Үүнтэйгээ уялдаад бараа, бүтээгдэхүүний хангалт, үнийн түвшин, бүс нутгуудаар өөр гарч байгаа. Энэ нь улсын хэмжээний дүнд тодорхой нөлөөллүүдийг үзүүлээд байгаа юм байгаа.

Тийм учраас хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг бүс нутгуудын түвшинд жигд хангалттай байлгах, бас нэг тогтвортой ойролцоо үнийн түвшин байх чиглэл дээр ер нь ямар бодлого тодорхойлж байна вэ? Жишээ нь, баруун бүс нутаг гэхэд өмнөх нийгмийн гэдэг юм уу үед газар тариалангийн үйлдвэрлэл тодорхой талбайн хэмжээнд хөгжсөн. Түүнийгээ дагуулаад бас гурилын үйлдвэрийн тодорхой хүчин чадлуудыг бий болгосон байсан. Үүнийг сэргээх талаар 2026 оны төлөвлөгөө хөтөлбөрт ямархуу байдлаар тусаж оров оо гэдэг асуудал байна. Үүн дээр нэг тодорхой хариулт авмаар байна.

Гурав дахь зүйл. Бид хэд ер нь гол нэрийн эрдсүүдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурч байгаатай холбогдоод эдийн засгийн өсөлт талаасаа ч тэр, төсвийн орлого бүрдэл талаасаа ч тэр зарим металлуудын олборлолтыг

нэмэгдүүлэх тухайлсан бодлого хэрэгжүүлэх гэж байна. Жишээ нь, “Алт-3” хөтөлбөрийг ч гэдэг юм уу.

Энэ хүрээнд манай Байгаль орчин, уур амьсгалын яам ер нь ямар бодлого чиглэлтэй байна вэ? Үндсэн ордууд дээрээ түшиглэх гээд байна уу, эсвэл шороон орд элдэв бусын юман дээрээ тэр чигт нь хэрэгжүүлэх гээд байна уу? Бид хэд чинь хоёр удаа том хөтөлбөр хэрэгжүүлээд бас байгаль эхэд хөөрхөн тийм хохирол, иргэдийн амьдрах гэдэг юм уу, уламжлалт аж ахуйдаа нэлээн харшилмаар нөхцөл байдлыг үүсгэсэн ийм сургамж бэлээхэнээ байж байгаа.

Тийм учраас эдийн засгийн хувьд тийм ч их ач холбогдолгүй илрэл гэдэг юм уу, ордуудыг түшсэн үйл ажиллагаа явууламгүй байгаа юм. Үнэхээрийн эдийн засагт том үр дүн авчрахаар тийм нөөц ордуудыг түшиглэсэн үйл ажиллагааг нэлээн тодорхой хяналт бодлоготойгоор, байгаль орчиндоо, бүс нутагтаа ээлтэй байхаар авч явах талаар ер нь ямархуу байдлаар төсөөлж байгаа вэ? Энэ 2026 оны хөгжлийн... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам гурав хариулна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд. Ж.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Би жоохон шүүмжлэлтэй хандмаар байгаа юм.

Уламжлал болоод явж байгаа 2028 он хүртэл хэрэгжихээр Их Хурлаар баталсан хөтөлбөрүүдийг ямар нэг үндэслэлгүйгээр Хөгжлийн яаман дээр шууд хассан байдал гарч ирээд байгаа юм.

- Одоо малын эрсдэлээс хамгаалахын тулд тэжээлийн үйлдвэрүүдийг л бүсчлэн байгуулах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх чухал байгаа юм. Үүнийг хасчхаж байгаа юм.
- Нөгөө түүхий сүүний нийлүүлэлт гээд сүүний аж ахуйнууд овоо босоод ирсэн. Тэнд явсан бүх бодлогыг бас хасаад хаячихсан. Одоо сүү нийлүүлж байгаа үед урамшуулал өгч байгаа. Байхгүй болж байгаа.
- Нөгөө шинэ дэвшилтэт ноолуурын ээрэх үйлдвэрлэл буюу самнасны дараа ээрэх хүчин чадлаа өргөтгөөд нэмүү өртөг бий болгох гэсэн бодлогыг бас хасаад хаячихсан.
- Нөгөө “Тэрбум мод” буюу ойн зурвас, газар тариалангийн талбайгаа хашаажуулаад барих асуудлыг бас хасчихсан.

- Өвлийн хүлэмжээр бид энэ хүнсний хувьсгалын 19 зорилтын гол хүнсүүдийг хүлэмжээр хангах зайлшгүй шаардлага байгаа. Тэрийг бас хасчихсан.
- Газар тариаланд үрийн аж ахуй нь бол онцгой чухал байдаг. Үүнийг бэхжүүлэх бодлогыг хасчихсан.
- Нөгөө жижиг, дунд үйлдвэрийг 5 жил дэмжээгүй. Энэ жил мөн дэмжээгүй. Ирэх жил ахиад л дэмжихгүй гээд л хасчихаж байна.

Гэтэл жижиг, дундын эрэлт ямар их байгаа билээ. Ялангуяа бүсчилсэн жижиг, дунд бизнесийг хөдөө аж ахуйн бизнесийг эрхлэхэд бүсчилсэн зээлийн бодлого гаргаж дэмжиж өгөхгүй бол явахгүй нь.

Баруун бүсийн хөдөө аж ахуйн бизнесийг дэмжих зээл, зүүн бүсийн гэж бүсчилсэн хэлбэрээр ингэж газарзүйн байрлалаар хязгаарлаж өгөхгүй бол үндсэндээ төвийн бүс өөрөө гол идэвхтэй бүсийн хувьд тэр хөрөнгө оруулалтын дийлэнхийг нь төвийн бүсэд шингэчихээд, бусад газар олдох олдоц их муу байна гэдгийг сая бүсчилсэн энэ уулзалтын үеэр маш их шүүмжлэл дагуулж байгаа юм.

Тэгэхээр үүнийг бүр зайлшгүй оруулж өгмөөр байгаа юм.

Зүүн бүсийн жижиг, дунд хөдөө аж ахуйн зээл бол зүүн бүсдээ л зарцуулагдаж байдаг. Тэгж бодлогоор тэр бүс нутагт хүн ажиллах, амьдрах, бизнес эрхлэх орчныг нь дэмжихгүй бол нөгөө төвлөрөл чинь ахиад л наашаа хотдоо төвлөрдгөөрөө л төвлөрөөд л, тэнд зээлийн хүрэлцээ, ажлын байр хязгаарлагдмал хэвээрээ л байгаад байх юм. Гэсэн ийм саналууд байна.

Тэгээд үүнийг Хөгжлийн яам яагаад хассан юм бэ гэдгийг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Энэ чинь Их Хурлаар батлагдсан бодлогууд шүү дээ. 3 жил, 4 жил тогтвортой яваад үр дүнд хүргэх ёстой. 2028 онд хэрэгжсэн байх учиртай бодлогууд байхгүй юу.

Тэгээд ямар хүн ямар мэргэжилтэнд ямар чиглэл өгөөд ингээд хасаад байдаг юм бэ гэдгийг ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Жоохон юм хийгээд жоохон амжилтад хүрнэ. Тэгээд тодорхой бус шалтгаанаар хасаад хаячихдаг. Байхгүй болгочихдог.

Б.Бат-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яам. Төрийн нарийн бичгийн дарга нь ирсэн үү. И.Батхүү түрүүний бичгийн дарга ирсэн. Тийм ээ. 4 номерын микрофон И.Батхүү дарга хариулъя.

И.Батхүү: Ж.Энхбаяр сайдын асуултад хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас нийт 37 санал, 433 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дүнтэйгээр ирсэн юм байна. Үүнээс 20 төсөл, арга хэмжээ, 285.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг манай яамны холбогдох газар, ажлын хэсгүүд нь ажиллаж байгаад суулгасан байна.

Ер нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ оны нэг сараас эхлээд салбарын яамдаас хуульд заасан шаардлагад нийцсэн, тэгээд батлагдсан журам, аргачлалын хүрээнд төсөл, арга хэмжээний саналуудыг ирүүлэх тухай бичиг хүргүүлээд, тухайн яамны бодлогын газартай манай яамны бодлогын газар нэгд хамтарч ажилласан. Энэ хамтын ажиллагааны үр дүнд гарч ирсэн төсөл байгаа. Одоо яг хариуцсан газрын дарга бас тодорхой төслүүд дээр тайлбараа хэлье.

Б.Бат-Эрдэнэ: И.Батхүү дарга аа, та Төрийн нарийн бичгийн дарга. Та өөрөө хариул. Танай яам яахаараа ийм олон түр орлон үүрэг гүйцэтгэгчтэй байдаг юм? Тэгээд яагаад энэ мэргэжлийн яамны оруулж ирж байгаа бодлого, хөтөлбөрийг танай яаман дээр хасаад байдаг юм? Та өөрөө Төрийн нарийн бичгийн даргын хувиар наад эрх үүргийнхээ хүрээнд наад асуудлаа өөрөө хариул. 4 номерын микрофоныг нээе.

И.Батхүү: Энэ арга хэмжээ бүрээр нь тайлбарыг нь унших уу? Дарга аа. Болох уу? Тийм ээ.

Нэгдүгээрт нь, төмс, хүнсний ногооны механикжсан баталгаат агуулах анхан шатны үтрэн байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх гэдэг арга хэмжээний санал.

Энэ байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн учраас тусгаагүй байна. Ер нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаадаагүй төсөл, арга хэмжээг заавал хэрэгжүүлэхгүй гэсэн үг биш. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх ёстой.

Улсын хөгжлийн төлөвлөгөөнд үндсэндээ хөрөнгө оруулалтын шинж чанартай үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлд нийцсэн арга хэмжээнд тусгаж байгаа.

Бусад үйл ажиллагаа, урсгал зардал, үйл ажиллагааны зардлын хүрээнд... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофоныг өгье. Та маш товч тодорхой хариулмаар байна. Улсын Их Хурлаар батлагдсан. Яагаад танайх дээр очоод хасагддаг юм бэ л гэж асууж байгаа юм. Маш товч тодорхой л хариулчих.

И.Батхүү: Хоёр дахь нь үр үржүүлгийн иргэн, аж ахуйн нэгжид урамшуулал олгох асуудал. Засгийн газрын чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын 7 дахь заалтад төрөөс олгож байгаа бүх төрлийн татаас урамшууллын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөлөлд судалгаа шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж 2025 оны Улсын Их Хуралд багтааж. Яасан гэнэ ээ? Тийм. Энэ манай хариуцсан хүмүүс урсгал зардлаа шийдэх боломжтой, үйл ажиллагаа явагдах боломжтой гэж үзээд энэ арга хэмжээ хассан байна.

Сэлгээний таримлын анхан шатны үр үржүүлэх гэдэг ажлыг мөн ижилхэн шалтгаанаар хассан байна.

Сорт сорих аргачлалыг боловсронгуй болгох гээд бас урсгал зардлынхаа хүрээнд шийдэх боломжтой.

Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх гэдэг асуудлыг бодлогын арга хэмжээ байгаа учраас санхүүжүүлэх боломжгүй гэсэн байна.

Б.Бат-Эрдэнэ: И.Батхүү дарга аа, ингэмээр байна. Та Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Мэргэжлийн байнгын хороо. Энэ Байнгын хороонд Эдийн засаг, хөгжлийн яамнаас саяын төсөл, хөтөлбөрүүд Улсын Их Хурлаар батлагдсан төсөл, хөтөлбөрүүд яагаад хасагдсан бэ гэдэг дэлгэрэнгүй тайлбараа Та Байнгын хороонд, одоо Л.Гантөмөр сайдад хэлээд Байнгын хороонд яаралтай ирүүл ээ.

Тэгэхгүй бол та одоо энэ яасан билээ, энэ юу гэсэн үг вэ гээд уншаад байхаар наадах чинь Та өөрөө ажлаа мэдэхгүй байна гэсэн үг шүү дээ.

Би яагаад танаас асуугаад байна гэхээр Ц.Эрдэнэбат даргаас асууж болно. Тэгэхдээ Ц.Эрдэнэбат дарга чинь өөрөө газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч болчихоод байгаа байхгүй юу. Та өөрөө Төрийн нарийн бичгийн дарга. Энэ түр орлон гүйцэтгэгчтэй холбоотой асуудал таны хариуцах ёстой асуудал байхгүй юу. Яагаад түр орлон гүйцэтгэгч нарыг өнөөдөр хүртэл жинхлээгүй, төрийн албаны зохих шалгалтыг өгүүлээгүй ингээд явж байгаа вэ гэдэг чинь өөрөө тантай холбоотой асуудал байхгүй юу.

Тийм учраас тань дээр энэ асуудлыг хариулах ёстой гэдэг утгаар нь ярьж байгаа юм.

Хоёрдугаарт, Ж.Батжаргал гишүүний асуултад хариулмаар байна. Ж.Батжаргал гишүүн асуулт асуусан. Эдийн засаг, хөгжлийн яам. Яах вэ Эдийн

засаг, хөгжлийн яамаа дуусгачихъя. Тэгээд дараа нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хариулт авъя.

Эдийн засаг, хөгжлийн яам Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? 4 номер И.Батхүү дарга.

И.Батхүү: Тийм. Ж.Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя.

Түрүүн “Алт-3” гээд хөтөлбөрийн хүрээнд ер нь Уул уурхай яамнаас боловсруулсан санал бол 4 тонн алтыг нэмэлтээр олборлож гаргах асуудал байгаа.

Энэ алтны экспортын гол нөлөөлөл бол гадаад валютын албан нөөцөд эерэг нөлөө үзүүлдэг. Яг төсвийн орлого талаасаа биш, валютын нөөц талаасаа авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа юм.

Тэр яг хамрагдах талбай хаана тэр алтны олборлох үйл ажиллагаа явуулах юм. Уул уурхайн яамнаас гаргасан жагсаалт дээр байгаа.

Б.Бат-Эрдэнэ: Төрийн албан тушаалтнууд дандаа ерөнхий хариулаад. Наадхыг чинь бид хаанаас ч олоод уншиж байна шүү дээ.

Гол асуудал өнөөдөр яг та нарын хассантай холбоотой гээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хэлчхээд байна. Тэр нь өөрөө анхан шат дээрээ очоод асуудал чинь хэрэгжихгүй болчихоод байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр буюу 2024-2028 хэрэгжих ёстой. Тэр нь жил болгон орж ирж байгаа хөгжлийн төлөвлөгөөн дээр хасагдах процессууд чинь явагдчихаад байгаа учраас асуудал хаанаа байна вэ гэдэг дээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр чиглэж оччихоод байна шүү дээ.

Тэгэхээр тэрийг л асууж байгаа юм. “Алт-3”-тай холбоотой асуудлуудыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас бид бас асуух асуултууд, хариултуудаа аваад явна. Түүн дээр яг тодорхой товч хариулт байна уу, байхгүй юу? Байхгүй бол байхгүй гээд явмаар байна. 4 номерын микрофон.

И.Батхүү: Улсын Их Хурлаар баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдийг заавал биелүүлэх, хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ дээр дурдагдсан асуудлуудыг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй гэдэг агуулгаар хэрэгжүүлэхгүй гэсэн үг биш ээ.

Түрүүн дурдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гээд эзэнтэй, хариуцах эзэнтэй хэрэгжүүлэлтийн хянах үзүүлэлттэй, цаг хугацаатай баримт бичиг. Засгийн

газрын тогтоолоор батлагдаад хэрэгжиж байгаа. Үүнийг хариуцсан яамд өөр өөрийнхөө хариуцсан чиглэл, салбараараа хэрэгжүүлээд явна.

Энэ яамны хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаанууд хөрөнгө оруулалтын шинж чанартай, мөн урсгал зардлаас санхүүжих үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлууд байдаг.

Тэгэхээр яамны хэрэгжүүлэх ёстой бүх ажлаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд оруулна гэсэн үг биш. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тухайн яамнаас хуульд заасан шаардлага, бас батлагдсан журам, аргачлалын дагуу боловсруулж ирсэн ажлуудыг тусгаж бодлогын нэн тэргүүний чиглэл, түүнийг дагасан төсөл... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: Танаас Улсын Их Хурал, Байнгын хороо юу хийх вэ гэж асуугаагүй шүү дээ. И.Батхүү дарга ажлаа мэдэхгүй байгаа юм байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам С.Одонтуяа сайд.

С.Одонтуяа: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр саяхан Засгийн газар дээр “Алт-3” хөтөлбөрийн асуудал орж ирсэн. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хамтарсан ажлын хэсэг гаргасан байгаа.

Энд хоёр чиглэлээр ажлын хэсэг гаргасан. Нэг нь энэ “Алт-3” хөтөлбөртэй холбоотой ажлын хэсэг. Нэг нь энэ гол мөрний урсац, голын голдиролтой холбоотой асуудал. Ингээд хоёр чиглэлээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна.

Ер нь энд хоёр асуудал байгаа. Нэг нь, Улсын Их Хурлаар орж шийдэх асуудлууд байдаг. Энэ ямар хуульд байгаа вэ гэхээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд байгаа саяын шороон ордтой холбоотой энэ заагт тодорхой хэмжээгээр тэр алт олборлох гэж байгаа газрыг нь тусгай хамгаалалтаас гаргах бол энэ бол заавал... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: С.Одонтуяа сайдын микрофоныг нэмж өгье.

С.Одонтуяа: Нэмж Улсын Их Хурлаар орох ийм заалттай байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлаар хэрвээ энэ асуудал орж ирвэл Улсын Их Хурал шийдээд явах боломжтой байгаа юм.

Ер нь яах вэ, Засгийн газрын хурал дээр би сайдын хувьд юу гэж хэлсэн бэ гэхээр одоо байгаа хуулийн дагуу лицензтэй, зөвшөөрөлтэй байгаа алтны

чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээ бүр дээд хэмжээгээр дэмжье. Заавал хуульд өөрчлөлт орно гэвэл энэ их хугацаа орно.

Тэгэхээр энэ байгууллагуудаа тэр хөнгөлөлттэй зээл байдаг юм уу, эд нарыг нь бодлогын хувьд сайн дэмжиж өгөөд хурдан ажилд нь оруулбал бас энэ алтны үнэ сайн байгаа дээр эдийн засагт хэрэгтэй байна гэдэг саналаа хэлсэн байгаа.

Нэг маш эрсдэлтэй юм гэхээр “Алт-1”, “Алт-2” хөтөлбөр хэрэгжиж байгаа үед бол маш их газар эвдрэлд орсон. Монгол Улс 2020-2024 онд гэхэд л нийт 12 мянга 117 га-д техникийн нөхөн сэргээлт, 3032 га-д биологийн... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: С.Одонтуяа сайдын микрофоныг нэмж өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр ер нь “Алт-1”, “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд маш гашуун сургамж авсан, маш их газар эвдэрсэн учраас бид бас энэ алдааг давтахгүй байх ёстой.

Дээрээс нь зогсоонгуут бас ямар эрсдэл үүсдэг вэ гэхээр бүгд нөхөн сэргээлтээ хийхгүй хаяад явдаг байсан. Тэгэхээр энэ бол өөрөө бүр их бохирдол үүсгэдэг.

Тэгэхээр одоо шинээр заавал 100 хувь нөхөн сэргээлтийн мөнгө нь урьдчилж авч байж хийлгэдэг ийм тогтолцоо үйлчилж байгаа.

Тэгэхээр энэ алтны компаниуд асуудал гайгүй шийдэгдэх байх гэж бодож байна. Гэхдээ Улсын Их Хурлаар орж гол гол асуудлууд шийдэгдэх юм.

Манайх гол мөрний урсац, энэ урт нэртэй хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол санаачлаад удахгүй Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүн нэмэлт асуулт. Байхгүй юу.

Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал ирсэн байгаа. Та бүхэнд зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг уншиж өгье.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 3.6.5 дахь заалт нэмэх:

“3.6.5.Цөлжилттэй тэмцэх, гангийн үр нөлөөг бууруулах, бэлчээрийн газрын тогтвортой менежментийг сайжруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа.

Зарчмын зөрүүтэй саналаар Улсын Их Хурлын гишүүд санал хураалт явуулъя. /алх цохив/

6 гишүүн зөвшөөрч, 7 гишүүн татгалзсанаар.

С.Замира горимын санал гаргая. С.Замира гишүүний микрофоныг нээе.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сая санал өгч амжсангүй аягүй хурдан дууслаа. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиж санал хураалт хийж өгнө үү гээд горимын санал гаргаж байна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Сонгобайн Замирагийн гаргасан саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт уналаа.

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүний микрофоныг нээе. Горимын санал гаргах.

М.Ганхүлэг: Уучлаарай. Санал хураалтын төхөөрөмж маань бас улаан асаад саналаа өгч чадсангүй.

Б.Бат-Эрдэнэ: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгох саналыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Улсын Их Хурлын гишүүд анхааралтай байхыг хүсэж байна. Санал хураалт. /алх цохив/

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүний гаргасан саналын дагуу хүчингүй болгосон саналыг ахин хүчингүй болгох санал хураалт 8 гишүүнээр дэмжигдлээ.

Одоо тэгэхээр унасан санал буюу хүчингүй болгох саналыг дахин хураалт хийнэ гэсэн үг. Санал хураалт.

Хүчингүй болгох санал хүчин дэмжигдээгүй учраас Э.Болормаа гишүүний санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.10 дахь заалт нэмэх:

“3.4.10.“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд газар тариалан, өмнөх түвшиндээ хүрч чадахгүй байгаа баруун бүс нутгийн

гурилын үйлдвэрийг сэргээн хөгжүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлж, үйлдвэрлэл, хангалтыг нэмэгдүүлэх суурийг тавих.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Улсын Их Хурлын гишүүдийг анхааралтай байхыг хүсэж байна. Санал хураалт. /алх цохив/

9 гишүүн буюу 69.2 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.11 дэх заалт нэмэх:

“3.4.11.Газар тариалангийн салбарт үрийн үйлдвэрлэл, чанарт тавих стандартыг онцгой анхаарч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон өндөр ургац өгдөг, чанартай, баталгаат үрээр хангах үрийн аж ахуйнуудыг бэхжүүлэх дэмжлэг урамшууллын тогтолцоо нэвтрүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүдийг анхаарал тавихыг хүсэж байна. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн 10 буюу 76.9 хувийн ирц хувьтайгаар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.12 дахь заалт нэмэх:

“3.4.12.Хүн амын хүнсний гол нэр, төрлийн бүтээгдэхүүн хүнсний түүхий эд улаан буудайн стратегийн нөөцийг бүрэн бүрдүүлэх.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Улсын Их Хурлын гишүүдийг анхааралтай санал өгөхийг хүсэж байна. Санал хураалт. /алх цохив/

Нийт гишүүд 61.5 хувиар тус санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.2.5 дахь заалт нэмэх:

“1.2.5.“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг эрчимжүүлж, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулж, бүсийн онцлогт тохирсон газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлд “Шинэ хоршоо 2.0” арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг.

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн санал гаргах гэж байна. Микрофоныг нээе.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

“Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбогдолтой заалт, агуулга 2026 оны энэхүү хөтөлбөрт огт тусаагүй байгаа юм. Тэгээд үндэсний хороо байгуулагдсан. Шадар сайд С.Амарсайхан сайдын харьяанд бас ажиллаж байгаа.

Ажлын төлөвлөгөө уялдааных нь дагуу өөрсдийнх нь гаргасан саналыг үндэслээд бүсийн хэмжээнд ер нь дундын хоршоог дэмжих чиглэл рүү “Шинэ хоршоо” хөдөлгөөний үйл ажиллагааг илүү эрчимжүүлъя гэсэн ийм зорилгыг төлөвлөгөөндөө тусгаад, тэр чиглэлийн ажлуудыг нь дэмжээд явъя гэсэн ийм санаачилга байгаа юм.

Хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжиж байгаа 4 хөтөлбөрийн 3 нь ороод тэгээд 1 нь яг ямар шалтгаанаар гэдэг нь мэдэгдэхгүйгээр хасагдаж байгаа нь ойлгомжгүй байгаа юм.

Тийм учраас “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх, шинээр байгуулагдсан бараг 8 мянга орчим хоршоодуудыг орхилгүйгээр цаашдаа үргэлжлүүлээд дэмжээд ажиллах энэ агуулгыг ерөнхий агуулгаар нь энд бас оруулъя гэсэн ийм саналтай байгаа.

Тэгээд би 3 санал гаргасан. Тэгээд дахин дахин үг хэлэхгүйгээр.

Хоёр дахь санал нь хоршооны гишүүн болон энэ залуу малчдыг ер нь дэмжих чиглэлийн хөтөлбөр лүү нэлээн анхаарал хандуулаад, хөдөө аж ахуйн сургууль болон мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвүүдээр дамжуулаад тодорхой урт болон богино хугацааны хөтөлбөр сургалтуудыг хийж байгаа.

Тэгээд энэ хөтөлбөрийг цаашдаа үргэлжлүүлэх чиглэл дээр “Малчин залуу-манлайлагч” энэ арга хэмжээг тусгаад явъя гэсэн ийм саналыг хоёрт нь оруулсан байгаа юм.

Гурав дахь нь, энэ 4 хөтөлбөр маань хоорондоо уялдаа холбоотой байх агуулгыг нэлээн гол анхаарал хандуулах нь зөв өө. Хүнсний үйлдвэрлэлийн байгууллагууд болон хоршоод, “Цагаан алт” чиглэлийн хөнгөн үйлдвэрлэлийн байгууллагууд болон хоршоод, ингээд тодорхой хоорондын уялдаа холбоог нь хангах дундын хоршоодууд гээд энэ бодлогыг салбарын яам гаргаад цаашдаа нэгдсэн байдлаар зохион байгуулаад явах нь зөв юм гэсэн ийм 3 санал байгаа юм.

Тэгээд байнгын хорооны гишүүд маань дэмжиж өгөхийг хүсье.

Б.Бат-Эрдэнэ: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн өөрийн гаргасан зарчмын зөрүүтэй саналуудыг тайлбарлалаа.

Тийм учраас 5 буюу Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.2.5 дахь заалт нэмэх:

“1.2.5.“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг эрчимжүүлж, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулж, бүсийн онцлогт тохирсон газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлд “Шинэ хоршоо 2.0” арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг. Санал хураалт. /алх цохив/

Нийт гишүүдийн 61.5 хувь дэмжлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.14 дэх заалт нэмэх:

“2.1.14.”Малчин залуу-манлайлагч” арга хэмжээг үргэлжүүлж, малчид хоршоологчдод мал аж ахуйн гаралтай түүхий эд, бэлтгэлийн үйл ажиллагаанд бүс нутаг, олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмших, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах ур чадварыг гадаад улсад олгоход чиглэгдсэн төслийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг. Санал хураалт.

Нийт гишүүдийн 76.9 хувь нь дэмжлээ.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.4.10 дахь заалт нэмэх:

“3.4.10.Малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн үе шат бүрт стандарт нэвтрүүлж, мал аж ахуйн салбарын кластерийн тогтолцоог бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 69.2 хувиар дэмжлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа танилцуулна.

Хуралдаанд оролцсон ажлын хэсэг Салдангийн Одонтуяа сайд, Жадамбын Энхбаяр сайд болон бусад ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье. Баярлалаа.

Дараагийн хэлэлцэх асуудал.

**Хоёр.Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт,
үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий
ажлын хэсгийн санал, дүгнэлт**

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсоно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсгийг танхимд орж ирэхийг урьж байна.

Та бүхэнд танилцуулга хийе.

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Байнгын хорооны тогтоолын төсөл үүний дараагаар хэлэлцэх ёстой.

Ажлын хэсгийн нэрс Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Төрийн нарийн бичгийн дарга, Цэндгомбын Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дангаасүрэнгийн Баярсайхан Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Б.Амарзаяа Хүнсний үйлдвэрлэлийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, Ч.Ариунтуяа Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж, үйлдвэрлэл технологийн парк хариуцсан ахлагч шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг орж ирж байна.

Ажлын хэсгийн дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна.

Ж.Батжаргал гишүүнийг урьж байна. Микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, П.Батчимэг, Ц.Идэрбат, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Б.Найдалаа, Н.Наранбаатар гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилд нь оруулсан.

Манай ажлын хэсэг 3 удаа хуралдаж, 36 дугаар тогтоолынхоо хэрэгжилтийн нэгдсэн тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас, мөн Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк, холбогдох бусад байгууллагуудын мэдээлэл, лавлагааг авч, мөн Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Зам, тээврийн яам, Боловсролын яам, Эрчим хүчний яам, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газруудаас нэмэлт мэдээллүүдийг авч санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Хяналт шалгалтын тухай хуулийн 9.9.5 дахь заалтын дагуу бэлтгэж Та бүгддээ хүргүүлсэн.

36 дугаар тогтоол тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнд 114 хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан юм. 62.6 хувийн хэрэгжилттэй байна гэж дүгнэсэн.

Тодорхой хэрэгжилт үр дүн сайн яваа. Бас анхаарал хандуулах ёстой, хэрэгжилт удаашралтай яваа бүлэг заалтуудаа танилцуулга мэдээлэлдээ бүрэн тусгасан гэдгийг хэлье.

Энэхүү тогтоол, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурал, Засгийн газраас 2023-2024 онд нийтдээ 1.3 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох бололцоог бүрдүүлж зээлийн хүүгийн хөнгөлөлтийг улсын төсөвт тусгаж ажилласан.

Нийт зээлийн 48.2 хувь нь эргэлтийн хөрөнгөд, 51.8 хувь нь хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулагдсан байна.

Салбараар нь авч үзвэл нийт зээлийн

- 27 хувь нь газар тариалангийн салбартаа,
- 65 хувь нь хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбартаа,
- 8 хувь нь мал аж ахуйн салбартаа чиглэгдсэн байна.

Зээлийн олголтыг байршлаар нь авч үзвэл

- Улаанбаатар хотод 71 хувь,
 - баруун бүсэд 3,
 - хангайн бүсэд 6,
 - төвийн бүсэд 15,
-

- зүүн бүсэд 5 хувь нь олгогдсон ийм дүн мэдээ гарч ирж байна.

Мэдээж энэ том тогтоол, цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн бодлогоор улсын төсөвт тусгаж тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Дээр нь мөн улсын төсөвт хөрөнгийн эх үүсвэрүүдийг тусгаж тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Татварын хөнгөлөлт дэмжлэгүүдээр дамжуулж тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Тэгээд энэ бүхний үр дүнд энэ салбарт 39 үйлдвэр шинээр байгуулагдаж, үүний

- 8 нь сүү боловсруулах чиглэлд,
- 10 нь мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлд,
- 12 нь гурилан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлд,
- 4 нь ус, шүүсний чиглэлд,
- 2 нь жимс жимсгэний боловсруулах чиглэлд,
- сав, баглаа боодол, давс үйлдвэрлэлийн чиглэлдээр 3 үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна.

Энэ хугацаанд тариалангийн талбайн ашиглалт 13 хувиар нэмэгдсэн байна. Нийтдээ 111 мянган га-гаар.

- Хүлэмжийн талбай 34 га-гаар буюу 28 хувиар,
- Зоорины багтаамж 37 мянган тонноор буюу 15 хувиар,
- Үтрэмийн багтаамж 34 мянган тонноор буюу 7 хувиар тус тус өссөн байна.

Энэ бүх мэдээлэл дээр тулгуурлаад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл дээр 9 тодорхой заалтыг тусгаж, Засгийн газартаа чиглэл өгөх ёстой гэж мэдээлэлдээ тусгаж оруулсан.

Тийм учраас ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэж дэмжиж өгөхийг Та бүгдээсээ хүсэж байна.

Энэ тайлан, дүгнэлт дээрээ тулгуурлаад “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг боловсруулсан. Энэ нь хэлэлцэх асуудлын гурав дээр байгаа учраас би тусдаа явах юм байна гэж ойлголоо.

Мэдээлэл хийж дууслаа. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалд баярлалаа.

Ажлын хэсгийн санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нанзадын Наранбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Пүрэвийн Батчимэг гишүүн гурваар санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуухаар тасаллаа.

Нанзадын Наранбаатар гишүүнийг урьж байна. Микрофоныг нээе.

Н.Наранбаатар: Энэ хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор 2023, 2024 онд өнөөдрийг хүртэл нийтдээ 1.2 их наяд төгрөг л зээл гаргасан юм байна.

Зээлийг нь байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод 71 хувь нь буюу дийлэнх олонх нь л олгогдсон байна. Тэгээд баруун бүс, хангайн бүс гээд 3 хувь, 6 хувь гээд, зүүн бүс 5 хувь гээд.

Говийн бүсэд ерөөсөө зээл олгогдоогүй байгаагийн учир шалтгаан нь юу байгаа юм бэ? Говийн бүсэд ажиллаад, энэ үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзаад явж байхад хийх юм их байна. Санаж сэдсэн юм их байна. Наад зах нь ингэний сүү боловсруулах үйлдвэр барих, махны үйлдвэр барих ийм хүсэл зорилготой тэмүүлэлтэй байдаг.

Ганц зовлон нь хөрөнгийн эх үүсвэр. Тэгээд төрөөс олгож байгаа зээл ерөөсөө олдохгүй юм. Хөдөө орон нутагт олдохгүй байна гэдэг ийм асуудлуудыг яриад байдаг.

Тэгээд Өмнөговь аймагт ингэний сүү боловсруулах нэг боломжийн дажгүй сайхан үйлдвэр баригдаад ашиглалтад орж байгаа юм. Тэгээд очоод бас үйл ажиллагаатай нь танилцахаар хувийн хөрөнгө оруулалтаар, гаднын зээл, тусламж. Ийм байдлаар л үйлдвэр цаашаагаа явж байгаа байдалтай байна.

Тийм учраас яагаад энэ хөдөө орон нутаг руу очихгүй байгаа юм. Бид чинь бүсчилсэн хөгжил, орон нутгаа хөгжүүлнэ, төвлөрлийг сааруулна гээд байгаа.

Тийм учраас зээл яагаад зөвхөн Улаанбаатар хотод олгогдоод явж байгаа юм. Ирэх онд энэ зээлийг бүсчлээд говийн бүс, баруун бүс, бусад бүсүүдэд тэдэн хувийг нь олгоно, төвдөө тэдэн хувийг нь олгоно гэж ингэж хуваарилж болохгүй юу. Бүх юмыг төвдөө эндээ олгогдоод байх юм уу? Үүний одоо учир шалтгаан нь юу байгаа юм бэ гэсэн нэг ийм асуулт байна.

Хоёрт, хүнснийхээ аюулгүй байдлыг ер нь хангаж чадаж байгаа юм уу? Мэргэжлийн хяналтыг татан буулгасан. Аймагт гэхэд 2 эрүүл ахуйч, хөдөө аж

ахуйн газар, 1 эрүүл ахуйч, эрүүл мэндийн газар. Маш олон уурхайнуудаар, олон хүн цугласан газруудаар гэдэсний халдварт өвчнүүд гарч байгаа.

Тэгэхээр асар олон хүмүүс халдварт өвчнүүд өвдөж байгаа юм. Энэ дээр хяналт шалгалт байхгүй. Тэнд хөдөө аж ахуйн газар ажиллаж байгаа эрүүл ахуйч нар, байцаагч нар маань хөрөнгө, төсөв, томилолт, унаа унаш байхгүй. Хяналт шалгалт хийх үйл ажиллагаагаа явуулж чаддаггүй. Үүн дээр яам яаж анхаарч байгаа юм. Цаашдаа хүнсний аюулгүй байдал, лаборатори, боловсон хүчний тогтолцоо, хяналтынхаа тогтолцоон дээр яаж анхаарч байгаа юм.

Б.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал хариулна. Микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Манай мэргэжлийн салбарын яамдууд нэмж хариулаарай.

Энэ төлөвлөгөө, тогтоол өөрөө 5 жилийн хугацаанд хэрэгжих юм. Эхний 2 жилийн бүтэн үр дүнгээ бид авч үзсэн ийм тайлан байгаа юм.

Тийм учраас 2023 он, 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийх нь үр дүн юман дээр дүн шинжилгээ хийсэн гэдгийг хэлмээр байна. 2025, 2026 онд үргэлжилж хэрэгжинэ.

Тийм учраас зээлийн бодлогыг бүс нутгаар нь баталж зарцуулж явах ёстой. Ингэж байж төрийн бодлогыг цогц хэрэгжүүлэх ёстой гэдэг байдлаар гарах гэж байгаа шийдвэр дотроо заалт тусгаж орууллаа гэдгийг хэлмээр байна.

Баталгаа, аюулгүй байдлын асуудал үнэхээрийн анхаарал татагдаж байгаа. Бид мэргэжлийн хяналтын байгууллагаа татан буугдсан.

Тийм учраас хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлт, хангалт, үйлдвэрлэлийнхээ бүхий л үйл явцад энэ талын хяналт нэлээн суларчихжээ. Үүнээс үүдээд нэлээн асуудлууд байна гэж үзээд бас гарах шийдвэр талдаа тодорхой заалт тусгаж оруулсан гэдгийг би хэлмээр байна.

Ингээд манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан нэмэлт хариулт өгье.

Б.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас сайд хариулах уу? Ж.Энхбаяр сайдын микрофоныг нээе. 7 номер. Нэмэлт хариулт.

Ж.Энхбаяр: Энэ маань өөрөө гол нэрийн 19 барааг дотооддоо үйлдвэрлэх зорилго бүхий. Нөгөө ковидын сургамжаас үр дүн аваад энэ хүнсний аюулгүй байдлыг хангах ийм зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа.

Тэгээд энэ 19 нэр төрөл маань яг өөрөө газар тариалан, төмс, хүнсний ногооны гол ургаж байгаа тэр бүс дээр тулгуурлаж явагдаж байгаа гол хангамжууд. Одоо төрөл бүрийн үр тариа, будаа, жимс жимсгэнэ, ургамлын тос, өндөг, хүлэмжийн ногоонууд, сонгино, байцаа, төмс, гурилан бүтээгдэхүүн, гахайн мах, тахианы мах гээд явахаар ерөөсөө л газар тариалан хаана байна, тэжээл хаана байна. Түүн дээр суурилсан аж ахуйнуудын асуудал орж ирээд нэг нөхцөл байдал.

Хоёрдугаарт, үйлдвэрлэл явуулахад орон нутагт дутагдаж байгаа нэг зүйл бол үйлдвэрийн дэд бүтэц байхгүй. Үйлдвэрлэлийн цэвэрлэх байгууламж байхгүй, үйлдвэрлэлийн уур байхгүй, үйлдвэрлэлийн усан татуургын систем байхгүй буюу... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя. 7 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Үйлдвэрлэл явуулах дэд бүтэц сул хөгжсөн нь бас үүнтэй шууд холбоотой.

Тэгээд бүх талын давуу талтай энэ бүс нутаг өөрөө энэ гол зээлийн гол ашиглалтыг өөртөө татхаад байгаа нь яах аргагүй бодит байдал. Иймд яамны зүгээс бүсчилсэн маягаар зээлийн эх үүсвэрийг гаргамаар байна. Говийн бүсэд зориулсан хөдөө аж ахуй, жижиг, дундын бизнес гэж. Зүүн бүс гэж. Бүсчилж гаргаж тэнд нь түгжиж өгөхгүй бол бусад бүсүүд үндсэндээ тийм төвийн бүстэй, Улаанбаатар хотын бүстэй өрсөлдөх ийм боломж хязгаарлагдмал.

Зээл зөвхөн арилжааны банкаар олгогдож байгаа болохоор банкны шалгуурыг бас давах нь амаргүй болчихоод байдаг.

Тэгэхээр гол арга бол бүсчлэх нь зүйтэй юм гэсэн ийм бодлого байна.

Таны мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан нь үнэхээр харамсалтай. Үнэхээр салбарын хяналтууд хөдөө аж ахуй хаанаа ер нь ганц манайх биш. Олон салбар эзэнгүйдэж байна.

Энэ чинь ард түмний эрх ашгийг хамгаалах үүднээс төрийн хяналтыг хэрэгжүүлж байсан байгууллага шүү дээ. Тэгээд яамд маань өмнө дандаа бодлогын яам гээд бүтэц, зохион байгуулалт нь хураангуйлсан хэлбэрт оруулаад бодлогын яам болсон байдаг. Гэтэл мэргэжлийн хяналт татан буугдаад салбарт болон хяналтыг шилжүүлэн өгөхөөр яамд маань өөрөө бодлогын биш үйл ажиллагааны яам болж хувираад, ингээд нэг ийм одоо байгаа бүтэц, зохион байгуулалт нь ч тэр, шинэ ирсэн чиг үүргээ ч хэрэгжүүлэхэд нэг л тийм учраа олохгүй байгаад байна.

Энэ бол ахиад л хэлэхэд төрийн хяналт шалгалтыг нь сулруулахад, олон түмний эрх ашиг хамгаалахад бас л их дутуу бодож хийсэн ийм л сөрөг шийдвэр байна гэдэг нь улам л амьдралд ил тод болоод байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь ахиж эргэн харж зайлшгүй хийх ёстой байх. Түүнээс бид яах вэ, цөөн тооны байцаагч, орон тоо яамны батлагдсан бүтцийн хүрээнд ороод ирсэн. Үүнийгээ тэгээд л төвлөрсөн болон төлөвлөгөөт хяналтуудаа гаргаад л тодорхой хэмжээнд үүрэг гүйцэтгүүлээд л явж байна.

Ялангуяа орон нутгийн түвшинд чадавх маш хүчтэй суларч байгаа байдал хаа сайгүй улс орны хэмжээнд анзаарагдаж байна.

Б.Бат-Эрдэнэ: Хариулж дууссан уу? Нанзадын Наранбаатар гишүүн тодруулга хийх үү? Тийм ээ. Хийхгүй юу?

Яах вэ, мэргэжлийн хяналтын байгууллагатай холбоотой асуудал өөрсдөөсөө л болсон шүү дээ. 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр Монгол Улсын Засгийн газар татан буулгах тогтоол гаргасан. Авлига арай л хэтэрсэн. Реконстракшн хийх ёстой гэж харсан. Тэгээд энэ процессууд явагдаж байгаа л гэж ойлгож байгаа.

Нөгөө талдаа үнэхээр хяналтын, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд асуудал үүсэж байгаа юу гэвэл үүсэж байгаа. Түүнтэй санал нийлнэ.

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Ганхүлэг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн манлайлал доор хүнсний хувьсгалын томоохон хөдөлгөөн өрнөөд 2 жил гаруй болж байна.

Хөдөө аж ахуйн салбарт нэлээн ахиц дэвшил гарсан нь нэг тодорхой жишээ нь энэ хөтөлбөр гэж би хувьдаа үздэг. Хуучин урамшуулал, татаас, ямар нэгэн байдлаар улсын төсвийг шууд сайд байдаг юм уу, тодорхой төрийн албан тушаалтан мэдэж шийдвэрлэдэг байж байсан асуудал энэ хөдөлгөөний тодорхой санаачилгаар өөр түвшинд очсон.

Энэ бол илүү бага санхүүжилтээр арилжааны банкнуудтай хамтарч томоохон үр дүн гаргах ийм хөтөлбөрийн гол концепц өнөөдөр хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа олон хөтөлбөрүүдийн эхлэл болж энэ дээр орж ирсэн.

Энэ агуулгаараа цаашдаа хөдөө аж ахуйн салбарын санхүүжилтийн одоогийн байгаа нөхцөл дэх хамгийн эрүүл зөв байж болох ийм хөрөнгө оруулалтын жишээ болж байгаа юм.

Тэгэхээр яах вэ, миний гол асуух гэж байгаа асуулт бол миний санаж байгаагаар 1 их наяд төгрөг үүний хүрээнд арилжааны банкуудаас гарна гэсэн ийм төсөөлөлтэйгөөр хөтөлбөр хэрэгжиж байгаа. Үүний дийлэнх нь эхний 2 жилдээ гараад явчхаж байгаа.

Тэгэхээр цаашдаа нөөц нөхцөл бололцоо бас ямар байх бол оо? Илүү түрүүлж хөтөлбөрт хамрагдсан компаниуд мэдээжийн хэрэг илүү үр шимээ хүртээд явж байгаа байх. Гэхдээ үүний цаана ямар хэмжээний нөөц үлдэх вэ? Цаашдаа энэ тогтоолоор дамжуулаад тодорхой бүсийн асуудлууд бас яригдах юм байна.

Тэгэхээр өмнөх эхэлж байгаа нөхцөлөөсөө арай багасах байх. Тэгэхээр энэ тохиолдолд бид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? Нөөц хэр үлдэж байгаа вэ гэдэг эхний асуулт байгаа.

Хоёр дахь нь, гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүний ерөнхийдөө 3 бүтээгдэхүүнээс бусад нь нэмэгдэж байна уу? Дотооддоо бүрэн хангаж байгаа бүтээгдэхүүнүүд дээрээ бид бүхэн экспортын тодорхой бодлогууд, энэ дээр ямар өсөлтүүд бий болгох чиглэл дээр яаж ажиллах вэ? Энэ бол энэ хөтөлбөрийн дараагийн шатын том зорилт байх ёстой гэж хараад байгаа.

Гурав дахь нь, цаашдаа аль нэг Их Хурлын гишүүд байдаг юм уу, тодорхой нөлөөний хүмүүс санаачлаад яваад байдаг энэ тогтолцооноосоо тогтвортой хөдөө аж ахуйн бодлогоо, хөрөнгө оруулалтын бодлогоо авч явдаг энэ тогтолцоо руу шилжихийн тулд бид ямар алхмыг хийх ёстой вэ? Ялангуяа энэ чиглэлийн банкууд, хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг тогтмол бий болгох чиглэл дээр бид анхаарах цаг нь бас болж байна гэсэн ийм саналуудыг би удаа дараа дэвшүүлээд байгаа. Энэ чиглэл дээр бас хэдүүлээ цаашдаа яаж ажиллах вэ гэдэг ийм гурван асуултыг асууя.

Б.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жигжидын Батжаргал хариулъя. Микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Тэгэхээр эхний 2 жилийн үр дүн бол бас тийм чамлахаар биш ээ. 62.6 хувийн хэрэгжилттэй явж байгаа юм.

Үлдэж байгаа хугацаанд бидэнд анхаарахаар олон зүйлүүд байна. Анх төлөвлөхдөө бид 1.7 их наядын хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэж тооцож байсан. Яг энэ тооцооллынхоо хүрээнд төр өөр дээрээ хүүгийн зөрүү буюу дэмжлэгийн хөрөнгөө тусгаад яваад байгаа.

Ер нь тийм учраас энэ төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн тооцоогоо дахиж нэг хийж үзээд, үүнд шаардлагатай хөрөнгөө улсын төсөв дээрээ ч, төр, хувийн хэвшлийн түншлэлээрээ ч шууд

хөрөнгө оруулалтын хэлбэрээрээ бүрэн тусгаж яв гэдэг асуудлыг тогтоолд зааж өгч байгаа.

1.7-гоор би хязгаарлахгүй байгаа. Энэ чинь амьдрал үргэлжилж байна. Шинэ шинэ одоо том зорилтууд дэвшигдэж байгаа учраас бас нэмэгдэл эх үүсвэрүүд гарахыг үгүйсгэхгүй юм байна гэж, энэ талаас нь харж энэ асуудалд тусгаж өгөх нь зүйтэй гээд явж байгаа гэдгийг зориуд би хэлмээр байна.

Дээр нь манай мэргэжлийн яам энэ холбогдох асуултууд дээр тодотгол мэдээллүүдээ нэмээд өгөх нь зөв байх гэж хэлэх байна.

Б.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр 7 номерын микрофон. Нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр маань нэлээн амжилттай хэрэгжсэн хөтөлбөр.

Тэгээд 2024 оны жилийн эцсээр 39 шинэ үйлдвэр байсан. Одоо 2025 оны нэгдүгээр улирлын мэдээгээр 52 хүнсний шинэ үйлдвэр ашиглалтад орж, 351 нэр төрлийн шинэ бараа үйлдвэрлэгдсэн байгаа.

Энэ үнэхээр аль ч хүнсний дэлгүүрүүд ороход эх орны үйлдвэрийн сав баглаа боодлын чанар сайжирсан, нэр төрөл нэмэгдсэн нь тодорхой байгаа.

Хөтөлбөрийн зарцуулалт гараад дууссан. Цаана нь ахиад улам өргөжүүлэх, хөгжүүлэх, хүрээд байгаа 60 хувийнхаа түвшинг бид 100 хувь хүрэхийн тулд дахин томоохон эх үүсвэрийг ахин тавиад цааш нь ахиад нэг урагшлуулмаар байна.

Энэ үйлдвэрлэгч нар маань урам зориг ороод нэлээн идэвхтэй, зоригтойгоор хөрөнгө оруулалтуудыг нэлээн сайн хийсэн. Ялангуяа 2024 он бол технологийн шинэчлэлийг хийхэд маш их том хөрөнгө оруулалтууд буюу... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: 7 номерын микрофон гүйцээж хариулъя. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үйлдвэрийн хүчин чадлууд нэлээн сайн өргөтгөсөн.

Тэгэхээр үр дүнгүй цааш цаашдаа гарна. Ахиж энэ эх үүсвэр тавихгүй бол одоо энэ авсан энэ хүрээнд л бид өргөтгөлийнхөө үр дүнг хүлээнэ.

Тэгэхээр 2026 оноос авхуулаад би дахиад нэг жил болгон хэдэн төгрөг тавиад яг энэ маягаараа зээлийн хүүгийн урамшуулал өгөх хэлбэрээр арилжааны банкаар шалгуурыг нь дамжуулаад олгоод явбал их зөв менежмент байна гэж ойлгож байна.

Экспорт. Дотооддоо хангахаас гадна экспорт байж байж энэ хөдөө аж ахуй өөрөө тогтвортой явна. Хамгийн сайжирсан зүйл бол мах үйлдвэрлэл, мах бэлтгэл дээр чанарын өөрчлөлтүүд гарсан. Олон улсын олон олон стандартыг манай мах үйлдвэрлэгч нар шаардлага хангаж эхэлсэн. Иймд экспорт 2 жил дараалан 300 сая долларын экспорт хийж байна. Жилдээ энэ чинь богийн толгойд шилжүүлбэл 5 сая хонин толгойд шилжсэн хэмжээний бид мал, махыг экспортод гаргаад байна.

Мөн бусад шинэ таримлууд, үр тарианы экспорт... /минут дуусав/

Б.Бат-Эрдэнэ: Ж.Энхбаяр сайдын микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ үр тарианы төрлийн таримлын экспорт нэлээн идэвхжиж ноднин 50 сая долларын таримлын экспорт гарсан. Энэ жил 100 сая доллар хүрэх бололцоотой байна.

“Цагаан алт”-ын хүрээнд бид 404 сая долларын ноолуурын экспорттой байгаа бол үүнийгээ энэ жил хэрвээ энэ бодлого маань тогтвортой явбал бид 600 сая долларт хүргэх ийм бололцоонууд байгаа юм.

Тэгэхээр энэ хэрэгжиж байгаа бодлогыг 2028 он хүртэл тогтвортой гээд жил болгон эх үүсвэрийг нэмэгдүүлээд явбал бодитой боломж байна. Бас сайн сайн үр дүнгүүд хүрч байгаа зүйлүүд их байна.

Хамгийн гол нь энэ салбар маань нийт Монгол Улсын ажиллах хүчний хоёр хүний нэг нь энэ салбарт ажиллаж байна. 600 мянган хүнийг ажлын байраар хангаж байгаа салбар. Тэгэхээр эдийн засгаасаа гадна нийгмийн тогтвортой байдлыг хангах, орон нутгийг эзэнтэй байлгах, тэр нь орон нутагтаа ажилтай амьдрах, орлоготой байлгах гол нөхцөлийг бүрдүүлж байгаа ийм улс төр нийгмийн ач холбогдол бас их өндөр байгаа юм.

Тийм болохоор энэ бодлогын арга хэмжээг тасралтгүй цааш нь үргэлжлүүлэх хэрэгтэй байна.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Энхбаяр сайд асуултад хариулж дууслаа. М.Ганхүлэг гишүүн тодруулга асуулт асуух уу? М.Ганхүлэг гишүүний микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Тийм. Хөтөлбөрийн үр дүнг дэмжиж байгаа.

Ж.Энхбаяр сайд маань бас төсөвт оруулж байна, оруулахгүй байна, дэмжиж байна, дэмжихгүй байна гэдэг энэ асуудлаасаа яаж гарах вэ л гэдэг тухай л хэдүүлээ нэг фокуслаад ярилцах хэрэгтэй байгаа юм.

Тогтвортойгоор санхүүжилтүүд. Хөдөө аж ахуйн салбар угаасаа л ер нь бусад улсуудтай харьцуулахад заавал ч үгүй тодорхой дэмжлэгтэйгээр явдаг ийм салбар байгаа юм. Тэр утгаараа үр дүнтэй байгаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хөдөө аж ахуйн байнгын төрөлжсөн банкныг бий болгох юм уу, нэг бол хувийн хэвшлийн оролцоо юмнуудыг илүү сайжруулах чиглэл дээр ямар агуулга гаргах юм?

Уул уурхай болон томоохон салбаруудын тодорхой хувь нь энэ чиглэл рүү ордог байх юм уу. Байнгын тогтвортой эх үүсвэрийн тухай хэдүүлээ ер нь ярих цаг нь болжээ л гэдэг саналыг хэлээд байгаа юм.

Тэгээд энэ чиглэлээр яг нарийвчилсан, мөн гаднын туршлагаудыг судалсан дараагийн түвшиндээ яах вэ гэдэг тухай ер нь тодорхой зүйл байна вэ гэдэг тухай.

Б.Бат-Эрдэнэ: Асуулт юм уу, санал юм уу? Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн санал хэллээ.

Ер нь яах вэ манай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүд маань бодлогын яамныхаа оруулж ирж байгаа асуудлыг их сайн дэмждэг, бусад Байнгын хорооддоо их сайн ойлголт өгдөг байх хэрэгтэй. Тэгэхгүй бол сая жишээлбэл хөгжлийн төлөвлөгөөнөөс авхуулаад хасагдсан. “Шинэ хоршоо”-ны үндсэн том хөдөлгөөн өрнүүлж байснаа хасагдсан гээд л олон асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ нийгэмд үүсэж байгаа холбоотой асуудал дээр Байнгын хорооны гишүүд маань бодлогын яамаа дэмждэг байх ёстой шүү гэдгийг хэлэхийг хүсэж байгаа юм.

Пүрэвийн Батчимэг гишүүн санал, дүгнэлттэй холбогдоод асуулт асууя.

П.Батчимэг: Энэ өнөөдрийн бид нарын тогтоол хэлэлцэх явцад хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай гээд ороод ирж байгаа юм.

Тэгтэл сая Н.Наранбаатар гишүүн бас хэллээ. Бид бас түрүүн ажлын хэсэг дээр ярьсан.

Ер нь хүнсний хангамж яриад байдаг, хүртээмж яриад байдаг. Гэтэл аюулгүй байдлаа бид орхигдуулаад, Монгол хүний эрүүл амьдрах, эрүүл явах энэ нөхцөл байдал бүр үнэхээр өдрөөс өдөрт дордож, алдагдсан байдалд орсоньг өнөөдөр Хүнс, хөдөө аж ахуйн яам, мэргэжлийн яамны хувьд хүлээн зөвшөөрч байгаа юу гэдгийг нэг асуумаар байна.

Тэгээд энэ тогтоолын 3 дээр сая ажлын хэсэг дээр өөрчлөлт оруулж лабораторийн тухай асуудлыг би хөндсөн байгаа. Тийм ээ.

Тэгэхээр Улаанбаатар хотод байж байгаа нэг лабораторитой. Тэрний хүртээмж, хүчин чадал маш муу.

Тийм учраас Улаанбаатар хотод нэгдсэн нэг үндэсний хэмжээний хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тэгээд шинжилгээний үндэсний лабораторитой болох ийм арга хэмжээг та ер нь авах тийм бодол байгаа юу, төлөвлөгөө байгаа юу?

Энэ дээр бид сая Засгийн газарт өгөх чиглэл дээр нэмэлт заалт оруулаад өгчихлөө.

Дараагийн асуудал. Одоо “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо”, энэ олон хөтөлбөрүүд дээр гарсан хэдэн их наядаар тооцогдох энэ олон зээлийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас ер нь намрын чуулганд Их Хурлын гишүүд болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд зээлийн эргэн төлөлт, зээл олгосон байдал, аж ахуйн нэгжүүд, ер нь тэрний эрэмбэ дараалал, ерөөсөө зээлийн талаар бидэнд дахин нэг мэдээлэл хийх, тодорхой мэдээлэл хийх ийм хүсэлтийг би бас хэлж байгаа.

Тэгэхээр сайд үүн дээр зээл олгосон, их гарсан тэр зээлийн том том тоо хаана яагаад энэ зээлүүд зарим газартаа хүртээмжгүй байдаг юм, зарим бүсүүдэд яагаад тийм бага байдаг юм? Үүний учир шалтгааныг нэг тайлбарлаж, намрын чуулганд Байнгын хороон дээр та нэг мэдээлэл хийх ийм бодол байна уу?

Б.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулъя. 7 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Энэ мэдээллийг зохион байгуулах бүрэн бололцоотой. Шаардлагатай гэвэл гол зээл олголт хийж байгаа арилжааны банкны удирдлагыг оруулж ирээд ер нь хөдөө аж ахуйн салбарын талаар Монгол Улс хэт уул уурхайгаас хараат эдийн засагтай улсын хувьд дараагийн том тулгуурт салбар бол хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар. Энэ салбарт хэрэгжиж байгаа бүх хөрөнгө оруулалт, мөнгөний бодлого ийм юм хэрэгжиж байгаа гэдэг талаар иж бүрэн танилцуулгыг бид бэлдэж хийе.

Хоёрдугаарт, лабораторийн асуудал. Би түрүүн бас Хөгжлийн яамтайгаа муудаад л байгаа юм. Бид боловсруулаад оруулсан. Хассан байгаа юм.

Үнэхээр хүнсний аюулгүй байдлын гол хангалт бол орон нутаг дахь лабораторийн иж бүрэн сүлжээ байх ёстой. Ядахдаа аймаг бүрд байх ёстой. Хилийн гол гол экспортод хийж байгаа боомтууд дээр байх ёстой. Ганц хүний

аюулгүй байдал биш, малын эрүүл мэндийн асуудал байгаа. Яагаад гэвэл мал эрүүл байж байж хүний хүнсний асуудал, их том суурь асуудал шийдэгддэг.

Тэгэхээр мал эмнэлгийн лабораториудыг чадавхжуулах, ургамлын лабораториудыг чадавхжуулах гээд ийм цогц арга хэмжээ зайлшгүй авах хэрэгтэй. Тэгээд харамсалтай нь яаж байгаа нь бүү мэд. Хасагдчихаад байх юм.

Тэгээд хүнсний аюулгүй байдал ямар байна гэхэд би “ноцтой байгаа” гэж хэлэх гэж байна. Ялангуяа гурил. Стратегийн хүнс болсон улаан буудай, гурилын хангамж дээр саяын Их Хурлын гаргасан шийдвэр бол маш ноцтой ийм эрсдэл, нөхцөл байдлыг үүсгэж байгаа.

Сая бид 4 хоног орон нутагт тариалалт дээр явлаа. Тариалалт эрс унаж байна. Улаан буудайн тариалалт. Намар гурил дутах нь тодорхой болж байна. Хангамж хүндэрнэ. Ахиад бид валют аваад гадаад улс орноос гурил, улаан буудайн эрэлд гарах ийм нөхцөл байдал бүрдэж байна.

Хойд хөршийн маань байдал амаргүй байна. Овоо нэг энхийн байдалд орох болов уу гэсэн бүх гэрээ хэлэлцээрүүд нь нураад уналаа. Ахиад хоёр тал буцаагаад цэргийн ажиллагаандаа шилжээд амаргүй байдал ахиад л хурц байдал үүслээ.

Үр тарианы гол бүс нутаг Украин, Оросын зөрчилдөөн үр тарианы улаан буудайн салбарт маш хүнд байдлыг үүсгэж байна. Дэлхийн хэмжээнд. Улс орон болгон нөөц бүрдүүлж байгаа. Улс орон болгон өөрийн тарифын бодлогоор дотоод үйлдвэрлэлээ дэмжиж байхад бид харин дотоод үйлдвэрлэлээ тарифын бодлогыг нь суллаж бусдын хараат байдалд оруулж байгаа энэ шийдвэр үнэхээр хүнсний хангамжид ноцтой эрсдэл учруулсан шийдвэр болж байна.

Тэгэхээр хүнсний хангамж, аюулгүй байдал хүнд байна.

Б.Бат-Эрдэнэ: Нэмэлт тодруулга. Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Ер нь хүнсний аюулгүй байдал үнэхээр алдагдаж байна гэдгийг л ерөөсөө ам амандаа яриад байгаа боловч ажил хэрэг болгож үүнийг төрийн бодлогын түвшинд Засгийн газар ямар нэгэн дорвитой арга хэмжээ авахгүй байгаад үнэхээр сэтгэл дундуур явж байгаа.

Энэ дээр намрын чуулганаас ирэх жилийн 2026 оны төсөв дээр хүртэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тусгайлан “хүнсний аюулгүй байдал” гэсэн сэдвээр ерөөсөө нэмэлт төсөв, хөрөнгө ийм юм батлуулж, дэлхийн стандартад нийцсэн үндэсний хэмжээний лабораторийг Улаанбаатар хотод, нийслэл хотод байгуулах арга хэмжээг сайд бүр тусгай бодлого боловсруулж оруулж ирэх хэрэгтэй.

Б.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж дууслаа. /алх цохив/

7 номерын микрофон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: П.Батчимэг гишүүн их чухал асуудал дэвшүүлээд байна.

Бид оруулсан материалаа ахиад оруулъя. Ер нь улс орны хэмжээнд лабораторийн чадавх, хүнсний аюулгүй байдал хангахад ийм ийм шаардлага байна гэдгээ оруулмаар байна.

Тэгэхээр Ж.Батжаргал гишүүний ахалсан ажлын хэсэг дээр энэ дүгнэлт дотроо лабораторийн чадавхыг бэхжүүлэх ийм бодлогыг оруул гэдэг дээр Засгийн газарт өгч байгаа чиглэл дотор оруулаад өгчих. Тэгвэл бид тэрийгээ бариад, манай Байнгын хороо ийм өдөр журам чиглэл өгсөн, Засгийн газарт үүрэгдсэн гээд би бариад явахад надад их хэрэгтэй байна.

Б.Бат-Эрдэнэ: Ойлголоо. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбоотой гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Санал дүгнэлттэй холбоотой үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн хэлэлцэх асуудал.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Ажлын хэсгээс “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон хүрэлцэн ирсэн ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Тогтоолын төслийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна.

Ж.Батжаргал: Ажлын хэсэг 36 дугаар тогтоолынхоо хэрэгжилтийн явцад үнэлэлт, дүгнэлт өгөөд, цаашид анхаарах, эрчимжүүлэх ёстой асуудлууд байна гээд 8 асуудлыг гаргаж ирж тавьсан.

Тийм учраас яг үүнтэйгээ уялдуулаад Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг боловсруулж Байнгын хорооныхоо гишүүдэд хүргүүллээ.

Тогтоох хэсгийн 3 заалттай, даалгах хэсгийн 8 заалттай ийм тогтоол боловсрогдсон.

Энэ хүрээнд саяын яриад байгаа хүнсний аюулгүй байдлын асуудал дээр тавих мэргэжлийн удирдлага, хяналтыг сайжруулах тухай асуудал байгаа юм. Үүнийг тогтолцооных нь хүрээнд авч үз гэдэг зүйл.

Дээр нь тэр нотолгоонд суурилж энэ хяналтаа хэрэгжүүл гээд нэгдсэн лаборатори хийгээд, гаалийн лабораториудынхаа хүчин чадлыг нэмэгдүүл гэдэг асуудлыг тусгаж өгсөн гэдгийг зориуд хэлмээр байна.

Дараа нь бид төрийн бодлого тогтвортой хэрэгжих ёстой юм. Нэг гараараа хүнсний хангамж, аюулгүй байдлаа сайжруулна гэххээд нэг гараараа өнөөхийгөө хийдэг янз бүрийн татваруудаа хөдөлгөөд байгаа нь энэ чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа баялаг бүтээгчдээ бид энэ шийдвэрүүдийн золиосонд оруулаад болж өгөхгүй байна.

Тийм учраас үүнийгээ тогтвортой байлга гэдэг асуудлыг зааж өгсөн. Дотоодын зах зээлээ хамгаал гэдэг асуудлыг хэлж өглөө гэдгийг зориуд хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл манай гишүүдээс гарч ирээд байгаа юм. Үнэхээрийн энэ хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудлын асуудал, энэ рүү чиглүүлж байгаа бодлого, хөрөнгө оруулалтууд бүс бүсээрээ харилцан адилгүй байгаад байна. Эхний 2 жилдээ гол хангалт, нийлүүлэлтээ авч явдаг бүсүүд рүүгээ илүү түлхүү явсан байна.

Тийм учраас үлдсэн хугацаанд бүсүүдийнхээ тэнцвэртэй хөгжлийг хангах, хангалт, нийлүүлэлтийг нь сайжруулах хүрээнд төрийн бодлого, хөрөнгийн эх үүсвэрийг чиглүүлэх ёстой. Ингэхийн тулд бүсээр нь зээлийн бодлого юмнуудыг нь тогтоож, цогц төлөвлөгөө болгож хэрэгжүүлэх ёстой гэдэг байдлаар нь асуудалд хандаж тогтоолдоо тусгаж оруулсан гэдгийг хэлье.

Би нэмж нэг хэлэх зүйл. Даалгах хэсгийн 3 дугаар заалт дээр тэр цэцэрлэг, сургууль гэдэг үгийг авах хэрэгтэй юм байна.

Бид ерөөсөө хоол үйлдвэрлэлтэй холбоотой хяналт суларсантай холбогдуулаад зарим томоохон ажилчин, албан хаагчидтай газрууд дээр хоолны хордлого, янз бүрийн асуудлууд үүсээд байна.

Тийм учраас энд тавьдаг төрийн хяналтыг сайжруулах ёстой гэдэг зүйл ярьсан юм. Гэтэл дан ганц өнөө төрийн худалдан авалттай холбоотой асуудал нь тусгагдаад орчхож.

Тийм учраас би сургууль, цэцэрлэг гэдгийг нь авах юм бол “хоол үйлдвэрлэл” гэдэг үгээрээ нийтээрээ орж болох юм байна гэж ингэж харлаа. Тийм учраас би 3 дугаар заалтаас энэ үгийг нь авъя. Тэгээд Та бүгдийг тогтоолын төслөө дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалд баярлалаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Пүрэвийн Батчимэг гишүүнээр тасаллаа. Пүрэвийн Батчимэг гишүүн асуултаа асууя.

П.Батчимэг: Тогтоолын 3 дугаар зүйл дээр нэмэлт, өөрчлөлт сая оруулсан. Үүнийг уншаад танилцуулчихъя.

Хүнсний сүлжээнд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдалд тавих хяналтын бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлагын тогтолцоог бий болгох, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, хоол үйлдвэрлэл болон бусад үйлчилгээ, хүнсний худалдаа, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, ул мөрийг мөрдөн тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэх, импортын хүнсний баталгаат байдалд хяналт тавих гаалийн болон дотоодын хүнсний бүтээгдэхүүн аюулгүйн үзүүлэлтээр сорил шинжилгээ хийлгэх лабораториудын хүчин чадал. Хилийн лабораторийн гэж байна. Хилийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах болон нийслэл Улаанбаатар хотод тусгайлсан нэгдсэн хүнсний шинжилгээний лабораторийг шинээр байгуулах гээд ийм юугаар өөрчилж.

Б.Бат-Эрдэнэ: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт биш, редакцын засвартай холбоотой асуудлыг хөндлөө.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байхгүй байна.

Тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Тийм учраас тогтоолын төслийг баталъя гэдэг саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Нийт гишүүд 69.2 хувиар дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Жигжидийн Батжаргал болон Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг нарын редакцын засваруудыг оруулаад тогтоолын төслийг баталснаар танилцуулж дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан учраас хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийнхэнд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 18 минут үргэлжилж, 15 цаг 21 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД